



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 13 өдөр

Дугаар А/584

Булган сум

Бог малын шилжилт хөдөлгөөнийг  
зарим сумдад хязгаарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.3, 18.4 дэх хэсэг, аймгийн Онцгой комиссын 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 09 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын гоц халдварт хонины цэцэг өвчин Могод сумын 2 дугаар баг Хүйтний аманд батлагдаж, өвчин тархах эрсдэл өндөр байгаа тул Гурванбулаг, Могод, Дашинчилэн, Баяннуур, Сайхан, Рашаант сумдаас бог малын шилжилт хөдөлгөөн хийхийг 2024 оны 08 дугаар сарын 13-ны өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 23-ны өдөр хүртэлх хугацаанд хориглосугай.

2. Мал, амьтны гоц халдварт өвчний талаар мэдээлэл, сэрэмжлүүлэг зөвлөмжийг малчид иргэдэд хүргэх, малын эмч нарыг мэргэжил арга зүй удирдлагаар хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн), илэрсэн зөрчлийг арилгуулах шуурхай арга хэмжээ авч ажиллахыг Цагдаагийн газар (Л.Ганбаяр), Онцгой байдлын газар (Н.Хишигдорж), захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумын Засаг дарга нарт, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Жаргалсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  БАРИУН-ЭРДЭНЭ

